



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2025 оны 10 сарын 08 өдөр

Дугаар 4/1547

Есөнбулаг сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.3 дахь хэсэг, аймгийн Засаг даргын удирдлагын зөвлөлийн 2025 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 26 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас 2025 оны 10 дугаар сарын 13-ны өдрөөс 2025 оны 10 дугаар сарын 14-ний өдрүүдэд зохион байгуулах "Төрийн болон орон нутгийн нэгдсэн цахим систем"-ийн программ хангамжийг ашиглалтад бүрэн нэвтрүүлэх, мэдээллийн санг бий болгох сургалт, хэлэлцүүлэгт санхүүгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Үйл ажиллагааны зардалд зарцуулагдах 4,000,000 (дөрвөн сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, тайлагнаж ажиллахыг Санхүү төрийн сангийн хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

